

## Улаанбаатар хот дахь ХБИ-ийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (JICA/DPUB)

### Мэдээллийн эмхэтгэл No.28 2019.07



Хэдий оройтсон ч гэлээ төсөл маань өөрсдийн гэсэн логотой боллоо! Учир нь 4 дэх удаагийн Ази, Номхон далайн бүсийн CBID конгресс нь тус төслийн үйл ажиллагааг сурталчлан таниулахад тохиромжтой цаг хугацаа болох юм. Үүнээс улбаалан

Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загварын ойлголтыг таниулах чиглэлээр ажиллаж буй DPUB төслийн үйл ажиллагааны мэдээллийг илүү олон хүмүүст хүргэх болно. Тус лого нь DPUB төслийг илэрхийлэх нил ягаан өнгөтэй. Нил ягаан өнгө нь улаан болон цэнхэр өнгийн нийлбэр бөгөөд янз бүрийн хүмүүсийн хамтын ажиллагааг бэхжүүлэх “тэгш хамруулах” гэсэн утгатай. Мөн дэвсгэр хэсэгт Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET)-ын хайрцаг, одны хэсгийг ч оруулсан байгаа бөгөөд энэ нь олон талт байдлыг илэрхийлж байгаа юм. Манай төслийн шинэ лого та бүхэнд танил болно гэдэгт итгэлтэй байна.

### Монгол Улсад анх удаа зохион байгуулагдах олон улсын хурлыг илүү амжилттай болгохын тулд бид юу хийж чадах вэ? (2019.06.17)

7-р сард “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн конгресс (CBID)” зохион байгуулагдах гэж байна. Тус хурал нь Монгол Улсад болох хамгийн анхны хөгжлийн бэрхшээлийн тухай олон улсын хурал юм. Гадаад, дотоодоос хөгжлийн бэрхшээлийн салбарын олон хүмүүс оролцох бөгөөд хурлын үеэр 100 гаруй хүний бүрэлдэхүүнтэй сайн дурын баг ажиллана. Оролцогчдыг угтах, үдэх, бүртгэх, хурлын үеэр чиглүүлэгч хийх гэх мэтээр “Монгол орны нүүр царай” болон ажиллах сайн дурынхны багт их сургуулийн оюутнууд, ахлах ангийн сурагчид, байгууллагын албан хаагчид гээд залуус нэгдсэн байгаа юм. Сайн дурынханд зориулж Хөгжлийн бэрхшээлийн тухай сургалт зохион байгуулсан бөгөөд “Хурлын үйл ажиллагааг илүү амжилттай болгоход бид ямар хувь нэмэр оруулж чадах вэ” гэсэн сэдвээр ярилцлаа. Тэд “Шаардлагатай туслалцааг үзүүлэхийн тулд юуны өмнө тухайн хүнээс юу хэрэгтэй талаар асуух хэрэгтэй”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэрхэн туслах аргачлалыг суралцмаар байна” гэх мэтээр санал солилцон, сургалтанд идэвхтэй хамрагдлаа.

### Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах сэдэвт сургалт (2019.06.05)

DPUB төсөл хэрэгжиж эхэлснээс хойш Улаанбаатар хотын дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр ажиллаж ирсэн ба тус ажил эрчимжих шатандаа ороод байна. Өнөөг хүртэл Монгол улс дотооддоо ХБИ-ийн оролцоотойгоор хүртээмжийн үнэлгээг хэрхэн хийх аргачлалыг заах, төрийн байгууллагуудын хүртээмжийн үнэлгээг хийн зөвлөмж боловсруулах, мөн хууль, бодлого, хүртээмжийн стандартыг нягтлах зэрэг олон үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн ба энэ удаа эдгээр үйл ажиллагаануудыг нэгтгэн дүгнэж, Япон улсад саадгүй орчинг хэрхэн бий болгосон түүх, аргачлалын талаар суралцахаар ирээд байна. Тухайлбал хууль, стандарт, зөвшөөрөл олгох тогтолцоо болон хяналтын тогтолцооны талаар сурч судлах төлөвлөгөөтэй байна. Тиймээс энэ удаагийн сургалтын багт БХБЯ, ЗТЯ, БХТ, ЗТХТ, ХНХЯ, ХБХХЕГ, МХЕГ, их сургуулийн багш болон ТББ-ын төлөөлөл 3 хүн орсон байгаа юм. Эдгээр оролцогчид маань нэг баг болж, зураг төслийн шатнаас эхлэн барилга баригдаж дуусах хүртэл явцад саадгүй орчинг бий болгох ажлыг зорилт болгож байгаа юм.

Хотыг саадгүй болгох нь зөвхөн ХБИ-д зориулагдсан зүйл биш. Өндөр настан, жирэмсэн ээжүүд, хүүхдээ дагуулж яваа эцэг эх, хүнд ачаа зөөж буй хүн гээд олон хүмүүс ашиг тусыг нь хүртэх бөгөөд бүхий л хүмүүст ээлтэй орчин бүрднэ. Энэ сургалт нь 10 жилийн дараах Монголыг бүтээх эхний алхам болж байгаа гэдэгт найдаж байна. Өнөөдрөөс эхлэн 2 долоо хоногийн хугацаанд хичээнгүйлэн суралцаад харих болно.



Үйлчилгээний аргачлалыг суралцаж буй сайн дурынхан



Япон дахь сургалтын оролцогчид

## Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах тухай Япон дахь сургалт ②

2019.06.06

Япон дахь сургалт эхлээд 2 дахь өдрөө үргэлжилж байна. Хөтөлбөр ёсоор үдээс өмнө нь “Орчны саадгүй байдлыг хангах талаар улсаас явуулж байгаа бодлогыг Чюүбү мужид хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай, түүний агуулга, тодорхой үйл ажиллагаа”-ны талаар Японы Дэд бүтцийн яамнаас мэдээлэл тавилаа. Тус мэдээллээс анхаарал татсан хэд хэдэн зүйл байсан. Орчны саадгүй байдал нь нийгмийн өндөр наслалттай холбоотой яригдаж ирсэн, төр захиргааны төв байгууллага болон орон нутгийн засаг захиргааны нэгжүүдийн хоорондын системтэй уялдаа холбоо, дэд бүтцийн саадгүй байдлаас гадна сэтгэл зүйн саадгүй байдлыг илүүд үзэж байгаа явдал байсан. Түүнчлэн саадгүй байдлын ач холбогдлын талаар бодитоор ойлгуулах зорилгоор тэргэцэр дээр суух, харааны бэрхшээлтэй хүний нөхцөл байдлыг биеэр мэдрэх дадлага хичээл оров. Үдээс хойш нь энэ удаагийн сургалтыг зохион байгуулж байгаа “AJU Бие даан амьдрах төв” дээр очиж, Монгол Улсын дэд бүтцийн хүртээмжийн талаарх хэлэлцүүлэг явууллаа. AJU нь Нагоя хотын төр захиргааны байгууллагатай хамтран хүртээмжийг сайжруулах талаар ажиллаж ирсэн ТББ юм. ХБИ-ийн оролцоо, үзэл бодлыг төрийн албаныханд оновчтой хүргэх нь маш их үр дүнтэй байдаг талаар ярьж байлаа. Мөн Монголын дэд бүтцийн хүртээмжийн өнөөгийн байдлын талаар ярилцаж, олон сайхан зөвлөгөө авав. Бид цаашид 2 долоо хоногийн турш Японы туршлагаас сайтар судлах зорилготой байна.



*Тэргэцэртэй болон харааны бэрхшээлтэй хүний нөхцөл байдлыг биеэр мэдрэх дадлага хичээл*



### JIICA DPUB фэйсбүүк хуудсанд **LIKE** дарж нэгдээрэй!!

Төслийн фэйсбүүк хуудсанд LIKE дарсан нийт хүний тоо **5117** болж, маш олон хүнд төслийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүрэх боллоо. Цаашид ч гэсэн олон сонирхолтой мэдээллүүдийг та бүхэнд хүргэхийн тулд хичээн ажиллах болно.

## Улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэл



Ахлах зөвлөх Чива Хисао

Томилолт, сургалтаар дамжин хөгжлийн бэрхшээлтэй иргэд, мэдээллийн технологи төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй холбоотой бусад олон мэдээллүүд APCD дээр төвлөрөх болсон. Иймээс APCD-ийн бас нэгэн үйл ажиллагаа болох Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн төвийн чадамжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж хэмээн бодох болсон. Тухайн үед Ази, Номхон далайн бүсийн хөгжингүй орнуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээлэл маш хомс байсан ба олон улсын байгууллагууд хүртэл хангалттай мэдээлэлтэй байгаагүй. Тиймээс APCD нь өөрсдийн цуглуулсан мэдээллийг улс улсаар нь ангилан “Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 жил”-ийн 12 зорилгод нийцүүлэн цэгцэлж, цахим хуудсанд нийтэлсэн. Энэ нь “Улс бүрээр нь ангилсан хөгжлийн бэрхшээлийн тухай мэдээлэл” байсан юм. Улс орнуудын мэдээллийг сэдэв тус бүрээр нь ангилж цэгцэлсэн байсан учраас маш сайнаар үнэлэгдсэн ба НҮБ-ээс ч өндөр үнэлгээ авсан. Улс орнуудын мэдээллийг нийтэлсний дараа цахим хуудас руу нэвтрэх хүмүүсийн тоо ч эрс нэмэгдсэнийг санаж байна. Ингээд эцсийн байдлаар 24 орны мэдээллийг нэгтгэснээр APCD-ийн Хөгжлийн бэрхшээлийн мэдээллийн төвийн үйл ажиллагаа ч жигдэрсэн.

### DPUB Холбоо барих хаяг

**Хаяг:** Монгол улс, Улаанбаатар-15160, Нэгдсэн үндэстний гудамж-5, Засгийн газрын 2-р байр, ХНХЯ

**Фэйсбүүк хуудас:** [https:// www.facebook.com/jicadpub](https://www.facebook.com/jicadpub)

**Цахим хуудас:** [https:// www.jica.go.jp/project/ mongolia/015/index.html](https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html)

**И-мэйл:** [dpub.jica@gmail.com](mailto:dpub.jica@gmail.com)